

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2024.12.09

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт			Төсөв /сая төг/	Хэрэгжилт	Хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин			
0	1	2	3	4	5	6	7
Албан хаагчдын нийтлэг нийгмийн баталгаа							
1.	Албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөнд албан хаагчдаас гарсан саналыг тусган хамт олноор хэлэлцүүлж, батлуулах	Төлөвлөгөөнд туссан саналын тоо	2	2	-	Албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг байгууллагын дотоод журам болон “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-тэй уялдуулан боловсруулж, албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаагаар ирүүлсэн 2 саналыг төлөвлөгөөнд тусган хамт олноор хэлэлцүүлж, нийт 22 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулсан. Төлөвлөгөө болон хэрэгжилтийг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан.	100
2.	Албан хаагчдад олгох үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдлийн хэмжээг холбогдох хууль тогтоомжийг үндэслэн шинэчлэн тогтоох	Цалингийн зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	90	80-аас дээш хувь	-	Цалингийн сүлжээг байгууллагын даргын 2024 оны А/01 тушаалаар шинэчлэн тогтоосон ба цалингийн зардал байгууллагын нийт төсвийн 90 орчим хувийг (ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын зардал ороод) эзэлж байна. Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол, УИХ-ын 2019 оны 21 дүгээр	100

						тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам” болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдлийг олгодог ба ур чадвар, удаан жил, ажил хавсарсны нэмэгдэл, мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хэмжээг холбогдох журмын дагуу тооцон олгож байна.	
3	Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлж, дүгнэн журмын дагуу шагнал, урамшуулал олгох	Урамшуулал авах албан хаагчдын тоо	28	28	-	- Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу үнэлгээний багийг байгууллагын даргын тушаалаар байгуулж, гүйцэтгэлийн зорилт арга хэмжээний үнэлгээ, мэдлэг чадварын үнэлгээ, албан хаагчдын хандлага, ёс зүй, ур чадвар, багаар ажиллах чадвараар тус тус үнэлж үнэлгээний мөрөөр бүх албан хаагчдад /28 албан хаагч/ мөнгөн урамшууллыг улирал бүр олгосон.	100
		Үнэлгээний мөрөөр шагнал авсан албан хаагчдын тоо	4	4-өөс дээш	-	- Нийт 27 албан хаагчтайгаас 23 албан хаагч салбарын болон орон нутгийн шагналаар шагнагдсан ба Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойг тохиолдуулан салбартаа үр бүтээлтэй ажиллаж байгаа 5 албан хаагч, 2 ахмад	

						ажилтныг төрийн дээд цол одон медалиар шагнуулах саналыг агентлагт хүргүүлж 1 ахмадын шагналын асуудлыг шийдвэрлүүлсэн. Төрийн захиргааны нийт 25 албан хаагчтайгаас 18 албан хаагч буюу 70 хувь нь зэрэг дэвтэй албан хаагчид эзэлж байна.	
4	Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан зэрэг дэв нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэх	Зэрэг дэв олгох, ахиулан олгох шаардлага хангасан албан хаагчдын тоо	5	10	-	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээрээ “маш сайн”, “хэвийн” үнэлгээтэй дүгнэгдсэн албан хаагчдын ажилласан жил, ур чадварыг харгалзан шаардлага хангасан нийт 12 албан хаагчийн (10 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулж, 2 албан хаагчид зэрэг дэв шинээр олгуулах) материалыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, шийдвэрлүүлсэн.	100
5	Албан хаагчид сар бүр унаа, хоолны мөнгөн олговрын зохих хэсгийг олгох	Хоолны нэмэгдэл авсан албан хаагчдын тоо	28	28		Байгууллагын дотоод журамд заасны дагуу хоолны нэмэгдлийг сар бүр нийт албан хаагчдад /28 албан хаагч/ олгодог.	100
		1 өдрийн хоолны мөнгөн дүнг нэмсэн эсэх (тийм-1, үгүй-0)	-	1		Албан хаагчдын 1 өдрийн хоол унааны нэмэгдэл 3000 төгрөг байсныг 8000 болгож нэмсэн.	
6	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга авах	Сэтгэл ханамжийн дундаж хувь	84	85-аас дээш	-	Албан хаагчдаас ажлын байрны таатай орчин, ажиллах нөхцлийн хэрэгцээ шаарлагыг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгааг 2024 оны 1 дүгээр улиралд бүх албан хаагчдаас авсан.	100
		Албан хаагчдын хамрагдалтын хувь	100	100		Сэтгэл ханамжийн дундаж түвшинг дээшлүүлэх арга хэмжээг төлөвлөн, албан хаагчдаас ирүүлсэн саналыг төлөвлөгөөнд тусгасан.	

						Албан хаагчдын сурч хөгжихөд таатай орчин нөхцлийг бүрдүүлж, дэвшилтэт технологи бүхий сургалтын танхимыг тохижуулах, ажиллах орчныг сайжруулж, барилгын дулаан алдагдлыг бууруулах, орчны өнгө үзэмжийг сайжруулахаар оффисын барилгын гадна фасадны засварын хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж, албан хаагчдаас гарсан саналыг бүрэн хэрэгжүүлсэн. Жилийн эцэст сэтгэл ханамжийн байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор дахин судалгаа авч дүгнэхэд 1 дүгээр улиралд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж түвшин 92 хувь байсан нь 100 хувь болж нэмэгдсэн байна. /Судалгаанд тус байгууллагын албан хаагчид сумдын Газрын даамлууд бүрэн хамрагдсан./	
7	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зарцуулсан зардал	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан хөрөнгийн хэмжээ (сая.төг)	28,5	10,0	-	Төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж албан хаагчдын тэтгэмж урамшуулал, дэмжлэг, тусламжид 160,4 сая.төг-ийг байгууллагын төсвөөс, ажиллах нөхцөл боломжийг сайжруулах зорилгоор 596,3 сая.төг-ийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлж, 756,7 сая.төг-ийг зарцуулсан байна. Тухайлбал: - Улирлын урамшуулалд 73,5 сая.төг - Оффисын барилгын тохижилт, гадна фасад, дээврийн засвар үйлчилгээнд нийт 339,3 сая.төг /ОНТ/ - 5-аас дээш жил ажилласан 14 албан хаагчдад тэтгэмж болох 85,8 сая.төг	100

						- Тоног төхөөрөмж сайжруулахад 21 сая.төг /ОНТ/ - Ажил үүргээ гүйцэтгэх авто машин худалдан авахад 236 сая.төг /ОНТ/ - Дотоод журамд заасны дагуу албан хаагчдад тусламж, дэмжлэгт зориулж 1,3 сая.төг Дээрх төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 14-ний 02/235 дугаар албан бичгээр аймгийн ЗДТГ болон ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн ба жилийн эцэст төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлэн тайланг албан хаагчдад танилцуулсан.	
Байгууллагын дотоод журамд заасан нийгмийн баталгаа							
8	Албан хаагч нь эрүүл мэндийн шалтгааны улмаас өвдөж, эмчлүүлэх тохиолдолд санхүүгийн тусламж үзүүлэх	Гүйцэтгэлийн хувь	100	100	-	Байгууллагын дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.3.2 дахь заалтад эрүүл мэндийн шалтгааны улмаас өвдөж, эмчлүүлэх тохиолдолд санхүүгийн тусламж үзүүлэх талаар тусгагдсан ба тайлант хугацаанд дээрх тохиолдол гараагүй.	100
9	Албан хаагчийн ахуй амьдрал, ар гэрт гачигдал тохиолдвол буцалтгүй тусламж үзүүлэх	Гүйцэтгэлийн хувь	100	100	-	Албан хаагчийн ар гэрт гачигдал гарвал тусламж үзүүлэх талаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7.2.1-д тусгагдсан. Тайлант хугацаанд 1 албан хаагчийн ар гэрт гачигдал гарч, 1 албан хаагч нас барж ар гэрт нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тусламж үзүүлсэн.	100
10.	Албан хаагч гэрлэх, хүүхэдтэй болох, хүүхэд үрчлэн авах, хурим хийхэд хүндэтгэл үзүүлэх, чөлөө олгох	Гүйцэтгэлийн хувь	100	100	-	Байгууллагын дотоод журмын 7.3.3-д “Албан хаагч гэрлэх, хүүхэдтэй болох, хүүхэд үрчлэн авах, хурим хийхэд хүндэтгэл үзүүлэх” заалт тусгагдсан ба	100

						тайлант хугацаанд шинээр хүүхэдтэй болсон 1 албан хаагчид 300,000 төрөг, шинээр шинэ байранд орсон 4 албан хаагчид нийт 1,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлж, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу шинээр хүүхэдтэй болсон аавд ажлын 10 хоногийн цалинтай чөлөө олгосон.	
11.	Албан хаагчдын хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй нөхцлийг хангах, өрөө тасалгааг аятай, тохитой орчин үеийн оффисын стандартын жишигт нийцүүлэн тохижуулах	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	310 сая.төг	Албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор байгууллагын гадна фасад, хурлын танхимын засвар тохижилт, ариун цэврийн өрөө, албан тасалгааны 1 өрөөнд засвар шинэчлэлийн ажил хийж нийт 339,3 сая төгрөгийн төсвийг сум, орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлж, засварын ажлыг хүлээн авсан.	100
12.	Албан үүргээ гүйцэтгэж байх үед нь хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагчийг хамгаалах арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	100	100	-	Албан үүргээ гүйцэтгэж байх үед нь хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагчийг хамгаалах заалт байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8.2.7-д тусгагдсан. Дээрх асуудлаар тайлант хугацаанд ямар нэгэн санал, гомдол гараагүй болно.	100
13.	Албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай материаллаг бааз, компьютер, техник хэрэгслээр хангах асуудлыг ажилтнуудаас санал авч судалгаа хийсний үндсэн дээр төсөвт тусгах замаар шийдвэрлэх	Албан хаагчдаас шаардлагатай тоног төхөөрөмжийн санал авсан тоо	1	1	-	Хэрэгцээт тоног төхөөрөмжийн судалгааг бүх албан хаагчдаас 1 дүгээр улиралд авч, ирүүлсэн саналыг нэгтгэн байгууллагын удирдлагуудад танилцуулсан. Барилгын хяналт гүйцэтгэхэд шаардлагатай 2 tab, хурдан скайнер, ухаалаг дэлгэцийг шинээр авч	100

						албанхаагчид үйл ажиллагаандаа ашиглаж байна.	
		Тоног төхөөрөмжөөр хангагдсан албан хаагчдын тоо	2	1-ээс дээш	2 сая.төг	Дээрх судалгаагаар болон албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаагаар ирүүлсэн саналын дагуу ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмжид нийт 21 сая төгрөг зарцуулсан ба суурин компьютер шинэчлэх саналыг ерөнхий газарт хүргүүлж шийдвэрлүүлсэн.	
14	Албан хаагчдыг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, эмнэлгийн оношилгоонд хамруулах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах	Албан хаагчдын хамрагдалтын хувь	100	100	2 сая.төг	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8.2.6, албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт уг асуудлыг зорилт болгон тусгасан. - Эрүүл мэндийн сайдын 2022 оны 139 дүгээр тушаалаар батлагдсан “Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоо”-г аймгийн Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх Эрүүл мэндийг дэмжих төвд хуваарийн дагуу байгууллагын албан хаагчид бүрэн хамрагдсан.	100
		Албан хаагчдын эрүүлжилтийн хувь, индекс	65	65-аас дээш	-	Архаг хууч өвчтэй албан хаагч байхгүй ба албан хаагчдын 30 хувь нь бөөр, 10 хувь нь нойр булчирхайгаа анхаарч эмчлүүлэх шаардлагатай гарсан ба ерөнхий эмчийн зөвлөсөн эмчилгээг албан хаагчид хийлгэсэн. Албан хаагчдын эрүүлжилтийн хувь, индекс 70 хувьтай байна. - Албан хаагчдыг жил бүр Улаанбаатар хотод эрүүл мэндийн үзлэгт үе	

						шаттайгаар хамруулдаг боловч Хэмнэлтийн тухай хуулиар хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглосон тул энэ онд Улаанбатар хотод багц үзлэгт хамруулаагүй.	
15.	Албан хаагдын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор тэдний дунд спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, 7 хоног бүр спорт зааланд тоглуулах, фиттнес, спининг, иог, бясалгал зэрэг төрөл бүрийн урлаг, биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах	Албан хаагчдын хамрагдалтын хувь	90	90-ээс дээш	-	Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах арга хэмжээг үе шаттайгаар жил бүр зохион байгуулдаг. -Долоо хоног бүрийн Пүрэв гарагт спорт зааланд тоглодог ба төв дээр ажилладаг 18 албан хаагч бүрэн хамрагддаг. -Улаанбаатар хотод зохион байгуулагдсан салбарын тэмцээнд 6 албан хаагч амжилттай оролцож эмэгтэй сагсан бөмбөгийн төрөлд “Хүрэл медаль” хүртсэн. -Дулааны улиралд долоо хоногт 1 өдөр өглөө эрүүл агаарт алхаж, дасгал хөдөлгөөн хийж хэвшсэн. -Төрийн байгууллагуудын дунд зохион байгуулагдсан спортын тэмцээнээр Шатар хүрэл медаль, сагсан бөмбөг /эмэгтэй/-хүрэл медаль, дартс /эмэгтэй/ алтан медаль хүртсэн.	100
16.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, чийрэгжүүлэх спорт, урлагийн арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	3	-	Газрын даамлуудыг чадавхижуулах сургалтын үеэр нийт албан хаагчдын дунд байгууллагын аврага шалгаруулах гар бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээнийг 2024 оны 1 дүгээр улиралд, бооцоот гар бөмбөгийн тэмцээнийг 2024 оны 4 дүгээр улиралд тус тус зохион байгуулсан.	100

						Мөн “Хүүхдийн баяр”-аар албан хаагчдын хүүхдүүдийг насны бүлэгт хувааж ахлах ангийн сурагчдад “Миний мөрөөдөл” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан, бага насны хүүхдүүдийн дунд “Миний гэр бүл” сэдэвт гар зургийн уралдаан зохион байгуулж, шалгаруулан дурсгалын зүйл гардуулсан. Дээрх бүтээлүүдийг байгууллагын цахим үйлчилгээний хэсэгт байршуулж, үзэсгэлэн гаргасан.	
17	Байгууллага, хамт олны дунд найрсаг, бие биенээ хүндэтгэсэн орчин, албан хаагчдын зөв харилцаа, хандлага, соёлыг төлөвшүүлэх, сайн туршлагыг дэмжих, дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Тухайн жилд зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	1	-	Газрын даамлуудыг чадавхижуулах сургалтын үеэр байгууллагын соёлыг дээшлүүлэх, хамт олны дунд найрсаг халуун дулаан харилцаа бий болгох зорилгоор “Байгууллагын соёл, ёс зүй, хандлага” сэдэвт сургалтыг Дундговь аймаг дахь эмэгтэйчүүдийн салбар зөвлөлөөс, “Гэр бүлийн харилцаа” сэдэвт сургалтыг Гэр бүл, хүүхэд хөгжлийн газраас авч албан хаагчид бүрэн хамрагдсан. Мөн 2023 онд хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээ, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх сургалтыг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагуудын албан хаагчдад зохион байгуулсан	100
		Албан хаагчдын хамрагдалтын хувь	100	100			
18	Эх үрсийн баяр, шинэ жилийн баяраар албан хаагчдын 0-18 хүртэлх насны хүүхдүүдэд бэлэг гардуулах	Хүүхдүүдийн хамрагдалтын хувь	100	100	3,5 сая.төг Байгууллагын төсөв	Төрийн албаны тухай хууль, байгууллагын дотоод журмын дагуу албан хаагчдын хүүхдүүдийг “Хүүхдийн баяр”, “Шинэ жил”-ийн баяраар хүлээн авч хүндэтгэл үзүүлдэг. Сүүлийн 2 жил Хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтыг хэрэгжүүлэн байгууллагын	100

						төсвөөс хөрөнгө зарцуулалгүй, албан хаагчдын хуримтлалын мөнгөнөөс гарын бэлэг авч албан хаагчдын хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлсэн.	
19	“Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын жил”-ийн хүрээнд байгууллагын албан хаагчдын хүүхэд, гэр бүл хамгааллын бодлогыг хэрэгжүүлж ажиллах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	-	2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/07 тоот тушаалаар “Эцэг эхийн зөвлөл”-ийг 3 гишүүнтэй байгуулсан ба хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж, төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлэн, үйл ажиллагааны тайланг хамт олонд танилцуулсан. “Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын жил”-ийн хүрээнд ахуйн эрсдэлийг бууруулах зорилгоор галын аюулгүй байдлыг хангаж болзошгүй эрсдлээс сэргийлэх зурагт хуудас зөвлөмжийг албан хаагчдын ар гэрт тараасан. Мөн ахуйн орчны эрсдлийг бууруулах үзлэгийг ар гэртээ зохион байгуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар чиглэл өгсөн.	100
20	Байгууллагын “Гэр бүлийн зөвлөл”, “Спорт хамтлаг” албан хаагчдын гэр бүл, залуу гэр бүлийг дэмжих зорилго бүхий арга хэмжээ зохион байгуулах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	-	“Эцэг эхийн зөвлөл”-өөс Хүүхдийн баярын үйл ажиллагааг зохион байгуулж, хүүхдүүдэд дунд гар зураг, эссэ бичлэгийн уралдаан зохиож, хүндэтгэл үзүүлсэн. Албан хаагчдын хүүхдүүдийн төрсөн өдрөөр аав ээжид нь хагас өдрийн цалинтай чөлөө олгож, мэндчилгээний зурагт хуудсыг байгууллагын дотоод хуудсанд байршуулдаг. “Спорт хамтлаг” 3 удаа уралдаант болон бооцоот тэмцээн зохиож, спорт өдөрлөгийг зохион байгуулсан.	100

						Мөн “Гэр бүлийн харилцаа” сэдэвт сургалтыг нийт албан хаагчдад зохион байгуулсан. Дээрх ажлын хэсгүүд жил бүр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулдаг ба энэ оны төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлэн тайланг албан хаагчдад танилцуулсан.	
21	Байгууллагын харьяат ахмадуудад “Ахмадын баяр”, “Сар шинийн баяр”-аар хүндэтгэл үзүүлэх	Ахмадуудын хамрагдалтын хувь	100	100	3,0 сая.төг Байгууллагын төсөв	Тус байгууллагын харьяат 14 ахмад байдаг ба “Ахмадын баяр”, “Сар шинийн баяр”-аар хууль журмын дагуу хүндэтгэл үзүүлдэг. Сар шинийн баяр болон ахмадын баяраар байгууллагын харьяат ахмадуудад нийт 2,800,000 төгрөгний гарын бэлэг гардуулж хүндэтгэл үзүүлсэн.	100
22	Өвөлжилт хүндэрч цас зудын байдал үүссэнтэй холбогдуулан малчин айлын албан хаагчдад 5 хүртэл хоногийн цалинтэй чөлөө олгох	Чөлөө өгсөн эсэх (тийм-1, үгүй-0)	-	1	-	2024 оны өвөл өвөлжилт хүндэрч цас зудын байдал үүссэнтэй холбогдуулан хөдөө гэртэй албан хаагчдын судлагааг гаргаж, судалгаанд хамрагдсан нийт 10 албан хаагчдад ажлын 5 хоногийн цалинтай чөлөө олгосон.	100
Дундаж хувь 100							

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.РЭНЦЭНДОРЖ

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.БОЛОРЧИМЭГ

